



ХҮҮХЭД СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 3 багц цагийн сургалтад хамрагдсан байх;
2. Хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр бүтээл хэвлүүлсэн байх (тоо хамаарахгүй);
3. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлагаа солилцдог байх; Үүнд:
 - хүүхдийн эмч нарын улсын зөвлөгөөнд оролцох
 - хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
 - “Монголын хүүхдийн анагаах ухаан” сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц хэвлүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 3 багц цагийн сургалтад хамрагдсан байх;
2. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр сүүлийн 3 жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх;
3. Сүүлийн 5 жилд хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр 2 ба түүнээс олон бүтээл хэвлүүлсэн байх ;
4. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлагаа солилцдог байх; Үүнд:
 - хүүхдийн эмч нарын улсын зөвлөгөөнд оролцох
 - хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
 - “Монголын хүүхдийн анагаах ухаан” сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц хэвлүүлэх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 3-5 багц цагийн сургалтад хамрагдсан байх;
2. Олон улсад мэргэшил дээшлүүлэх урт болон богино хугацааны сургалтад 5 жилд 2-оос доошгүй удаа хамрагдсан эсвэл мэргэшлийн чиглэлээрх хуралд оролцсон байх;
3. Сүүлийн 5 жилд хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр жил бүр бүтээл хэвлүүлсэн байх
4. Хүүхэд судлалын чиглэлээр сурах бичиг, гарын авлага бичих, мэргэшил арга зүйн чиглэлээр бодлогын баримт, бичиг боловсруулахад оролцсон байх;
5. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлагаа солилцдог, үндэсний хэмжээнд зөвлөн туслах үйл ажиллагаа хийдэг байх; Үүнд:
 - Хүүхдийн эмч нарын улсын зөвлөгөөнд оролцох;
 - Хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
 - “Монголын хүүхдийн анагаах ухаан” сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекцийг 1-р нэрээр буюу хариуцлагатай зохиогчоор хэвлүүлэх.